

ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,
2014 оны 6-р сарын 4-ний байдлаар*


2014 оны 6-р сарын 4-ний байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 0.4 хувь, өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад 1.2 хувиар өссөн байв.

Махны дундаж үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 1.1 хувь, үхрийн ястай махны үнэ 1.2 хувь, үхрийн цул мах 2.5 хувиар өсч, адууны махны үнэ 1.8 хувиар буурч, ямааны махны үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос үхрийн цул махны үнэ 1.0 хувь, хонины ястай махны үнэ 2.7 хувиар өсч, үхрийн ястай мах, адууны мах, ямааны махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 6-р сарын 4-ний байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7885 төгрөг, үхрийн /ястай/ мах 8785 төгрөг, үхрийн цул мах 11000 төгрөг, адууны мах 6605 төгрөг, ямааны мах 5780 төгрөгийн үнэтэй байв(Зураг 1).


Зураг 1.Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ



Гурилын үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 1.5 хувь, дээд зэргийн савласан гурил өмнөх сарынхаас 0.4 хувь, 1-р зэргийн гурилын үнэ өмнөх сарынхаас 0.7 хувь, 2-р зэргийн гурилын үнэ 1.0 хувиар өссөн байна. Харин өмнөх 7 хоногийнхоос дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 0.6 хувиар өсч, бусад төрлийн гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар цагаан будааны үнэ, элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна (Зураг2).

Зураг2



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад луувангийн үнэ 6.6 хувь, төмсний үнэ 2.2 хувь, байцааны үнэ 1.7 хувиар өсч, манжингийн үнэ, сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмсний үнэ 3.1 хувь, байцааны үнэ 1.1 хувиар өссөн бол бусад хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байлаа.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 9.0 хувь, “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 8.0 хувиар буурч, задгай сүүний үнэ 2.1 хувиар өссөн байна, өмнөх 7 хоногийнхоос “Элекстер” /0.5 л/ савласан сүүний үнэ 2.3 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.9 хувиар буурч, задгай сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Ургамлын тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, өндөгний үнэ өмнөх сарынхаас 0.6 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй, цэцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

Гурилын үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 680-1300 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос Архангай, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт 20-50 төгрөгөөр өссөн байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Булган аймагт 1300 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

Махны үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Дархан-Уул аймагт 200-500 төгрөгөөр өсч, Төв, Дорнод, Сүхбаатар аймагт 200-500 төгрөгөөр буурсан байна.

Хонины махны үнэ Хөвсгөл аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баян-Өлгий аймагт 250 төгрөгөөр өсч, Дархан-Уул, Дорнод аймагт 200-500 төгрөгөөр буурсан байна. Үхрийн махны үнэ Хэнтий аймагт 9500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 6250 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Увс, Ховд, Баянхонгор, Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар аймагт 200-500 төгрөгөөр өсч, Дорнод аймагт 200 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 6000 төгрөг байхад Өмнөговь аймагт 7800 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

Малын сүүний үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар малын сүү аймагт 700-3000 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Сүхбаатар аймагт 100-1000 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /3000 төг/ өндөр үнэтэй байна.

Цагаан будаа, элсэн чихрийн үнэ: 2014 оны 6-р сарын 4-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна. Аймгуудад цагаан будаа 1 кг нь 2000-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар аймагт 60-100 төгрөгөөр өсч, Ховд аймагт 100 төгрөгөөр буурсан байна. Элсэн чихэр 1 кг нь 1530-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.